



# БАЙГУУЛЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 1.1 Энэхүү Байгууллага үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойгоно. Үүнд:
- 1.1.1 **"Байгууллагын хөнгөлөлттэй үйлчилгээ"** гэж тухайн байгууллагад зориулсан хөнгөлөлт, урамшуулал үйлчилгээг хэлнэ;
- 1.1.2 **"Байгууллагын албан тоот хүсэлт"** гэж тухайн хэрэглэгчид үйлчилгээг авах давуу эрхт бичиг баримтыг;
- 1.1.3 **"Санхүүгийн хариуцлага"** гэж тухайн дугаарын төлбөр тооцоог бүрэн хариуцах этгээдийг хэлнэ. Байгууллага болон Хувь хэрэглэгч байна;
- 1.1.4 **"Байгууллагын групп үйлчилгээ"** хөнгөлөлттэй тарифаар ярих боломжтой үйлчилгээ ба 5-с дээш дугаарыг холбон тусгай дугаарлалтаар ярих үйлчилгээ;
- 1.1.5 **"Сарын суурь хураамж"** гэж Хэрэглэгч нь үйлчилгээг үзүүлэгчийн сүлжээ ашигласнаар сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
- 1.1.6 **"Багцын хэрэглээний эрх"** гэж Хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын суурь хураамжид багтаж буй (яриа, мессеж, дата эрх) үйлчилгээний эрхийг;
- 1.1.7 **"Нэмэлт үйлчилгээ"** гэж хэрэглэгчийн ашиглаж байгаа яриа, мессеж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй үйлчилгээг;
- 1.1.8 **"Үйлчилгээний төлбөр"** гэж Хэрэглэгчийн дугаарт бодогдсон, тухайн сарын хэрэглээний төлбөр, сарын суурь хураамж, бусад холбогдох төлбөр, хөнгөлөлт болон НӨАТ зэргийн нийлбэр дүнг;
- 1.1.9 **"Үйлчилгээ кооронд шилжих"** гэж Хэрэглэгч дугаар солилгүйгээр ашиглаж буй багцаа өөрчлөхийг;
- 1.1.10 **"Дугаар хадгалах үйлчилгээ"** гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 12 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж, хадгалуулах үйлчилгээг;
- 1.1.11 **"Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг түр хаах"** гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 3 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж, хадгалуулах үйлчилгээг;
- 1.1.12 **"Эзэмших эрх шилжүүлэх"** гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй дугаарыг бусдын нэр дээр шилжүүлэх үйлчилгээг;
- 1.1.13 **"Дугаар солих"** гэж Хэрэглэгчийн эзэмшиж буй дугаарын сүүлийн 4 оронг солих үйлчилгээг;
- 1.1.14 **"Сим карт сэргээх"** гэж Хэрэглэгч шинээр сим карт худалдан авахыг;
- 1.1.15 **"МОНГОЛдоо үйлчилгээ"** гэж Хэрэглэгчийн гарах яриа, мессеж хэрэглээ хийсэн дугаарын жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг, эсвэл Дата үйлчилгээний хэрэглээний жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг;
- 1.1.16 **"Үйлчилгээ зогсоох"** гэж орох гарах яриа, мессеж, дата үйлчилгээний эрхийг зогсоох;
- 1.1.17 **"Биллинг цикл"** гэж сарын эхний өдрөөс сарын сүүлчийн өдөр дуусталх хугацааг;
- 1.1.18 **"МОНГОЛдоо үйлчилгээ"** гэж яриа болон дата эрхтэй дараа төлбөрт үйлчилгээг;
- 1.1.19 **"InLive үйлчилгээ"** гэж дата эрхтэй дараа төлбөрт үйлчилгээг;
- 1.1.20 **"Зүй зохисгүй хэрэглээ"** гэж бусад хэрэглэгчийг залхаах, дарамтлах, гутан доромжлох, өөр бусад байдлаар бусдын амгалан туйван байдлыг алдагдуулах, сүлжээний хэвийн үйл ажиллагааг саатуулах, нэг дор их хэмжээний мессеж илгээх, зар сурталчилгааны шинжтэй болон хуулиар хориглосон өгөгдөл дамжуулах; бусдад хүндрэл учруулах зэргээр үйлчилгээний нөхцөлд тусгаагүй хэрэглээг;
- 1.1.21 **"Ноцтой зөрчил"** гэж байгууллага нь байгууллагын үйлчилгээний төлбөрийг төлөх хугацааг хэтрүүлсэн болон үйлчилгээний төлбөрийн хуваарийг удаа дараа зөрсөнхийг ойлгоно;
- 1.1.22 **"Олон улсын яриа үйлчилгээ"** гэж олон улсын яриа үйлчилгээний барьцаа байршуулсан хэрэглэгч 002 гарцыг ашиглан гадаад улс руу дуудлага хийх, мессеж илгээх үйлчилгээг;
- 1.1.23 **"Олон улсын роуминг үйлчилгээ"** гэж Хэрэглэгч гадаад улсад зорчихдоо өөрийн дугаараа ашиглан гадаадын операторууд /зөвхөн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гадаадын операторууд/-ын сүлжээг ашиглах үйлчилгээг ойлгоно;
- 1.1.24 **"Хурууны хээ уншуулагч"** гэж Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системийн мэдээлэлд үндэслэн хэрэглэгчийн хурууны хээг таньж, улсын бүртгэл дахь мэдээллийг хэрэглэгчийн мэдээллийн санд татан авах зориулалт бүхий төхөөрөмж;
- 1.1.25 **"Тоон гарын үсэг"** гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, үг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төлвийг;
- 1.1.26 **"Идэвхитэй төлөв"** гэж төлбөрийн улмаас, хэрэглэгчийн хүсэлтээр хаагдсанаас бусад төлвийг хэлэх;
- 1.1.27 **"Эзэлийн мэдээллийн сан"** гэж Эзэлийн мэдээллийн тухай хууль болон Төв Банк /Монголбанк/-тай байгуулсан гэрээний дагуу авлага барагдуулах арга хэлбэр;
- 1.1.28 **"4G LTE үйлчилгээ"** гэж интернетээс файл татаж авах, илгээх хурдаараа өндөр хөдөлгөөнт холбооны 4-р үеийн технологи;
- 1.1.29 **"Загдгай хэрэглээ"** гэж багцад дагалдах яриа, мессеж, дата эрхийн хязгаараас давсан нэмэлт хэрэглээг;
- 1.1.30 **"eSIM"** гэж үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн QR кодыг уншуулж өөрийн гар утас, төхөөрөмжинд биет бус симээр дугаар суулган ашиглах үйлчилгээг хэлнэ;
- 1.1.31 **"ДАН систем"** гэж Төрийн танилт нэвтэрлийн нэгдсэн систем буюу иргэний цахим орчинд таньж баталгаажуулан ХҮР системээс улсын бүртгэл дахь мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд татан авах үйлчилгээг;
- 1.1.32 **"Мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудас"** гэж "Скайтел" ХХК нь Хэрэглэгчид өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1.1.1, 6.1.2, 6.1.4, 8.1, 8.2, 8.3, 8.4, 9.2.1, 18.1-2-Улсын бүртгэлийн хуулийн 12.2-1-түс тус заасны дагуу мэдээллийн эзэнд танилцуулж авсан зөвшөөрлийн нөхцөлийг;
- 1.1.33 **"Тан код"** гэж Хэрэглэгч үйлчилгээг авах үед нэг удаа ашиглах оронтой тоон илэрхийлэл бүхий баталгаажуулах код;
- 1.1.34 **"MULTI SIM"** гэж дараа төлбөрт үйлчилгээний /МОНГОЛдоо, InLive/ багцад дагалдах дата эрхээсээ 3 хүртэлх симээр нэмэлт төхөөрөмжүүдэд зэрэг ашиглах үйлчилгээг;

## ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

### 2.1 Шинэ хэрэглэгч болох

- 2.1.1 Шинэ хэрэглэгч болохдоо 5 хүртэлх дугаар байгууллага үйлчилгээгээр авах бол үйлчилгээний салбарт хандаж авна.
- 2.1.2 5 ба түүнээс дээш дугаар эзэмшигч болох бол Харилцагч хариуцсан менежер хандаж шинэ дугаар авна.
- 2.1.3 Хэрэглэгч дараах бичиг баримтыг бүрдүүлэн байгууллага үйлчилгээний хэрэглэгч болно. Үүнд:
  - 2.1.3.1 Хувиараа төлбөрөө хариуцах бол цахим үнэмлэх эсвэл хуруу уншуулах болон тоон гарын үсэг, ажлын үнэмлэхтэй өөрийн биеэр;
  - 2.1.3.2 Байгууллага төлбөрөө хариуцах бол байгууллагын гэрчилгээ, тамга, удирдах ажилтны гарын үсэг байх;
- 2.2 **Бүртгэлийн хураамж**
  - 2.2.1 Шинэ хэрэглэгч нь сонгосон дугаарын бүртгэлийн хураамжийг Хавсралт 2-ын 2.1-д заасны дагуу төлнө.
  - 2.2.2 eSIM сонгосон хэрэглэгч үйлчилгээний салбар болон Харилцагч хариуцсан менежер хандаж Хавсралт 1-ийн 1.1 болон 1.1.1-д заасан бүртгэлийн хураамж болон Хавсралт 2-ын 2.5-д заасан QR кодын төлбөрийг төлнө.
- 2.2.3 MULTI SIM үйлчилгээг биет симээр авч байгаа үед бүртгэлийн хураамж 3000₮, eSIM-ээр авч байгаа бол 5000₮ төлнө.

### 2.3 Шаардлагатай бичиг баримт

- 2.3.1 Гэрээний өргөдлийн маягтад бөглөгдсөнөөр Байгууллага санхүүгийн хариуцлага хүлээх бол албан тоотыг үндэслэн аливаа үйлчилгээг үзүүлнэ.
- 2.3.2 Гэрээний өргөдлийн маягтад бөглөгдсөнөөр ажилтан санхүүгийн хариуцлага хүлээх бол иргэний үнэмлэх, хурууны хээ уншигчийн мэдээлэл болон тоон гарын үсэг зуруулан үйлчилгээг үзүүлнэ.
- 2.3.3 Аливаа үйлчилгээ гэдэгт дараах үйлчилгээнүүдийг хамруулна. Үүнд:
  - 2.3.3.1 Дугаар нэмж авах
  - 2.3.3.2 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар хаах, нээх, хадгалах;
  - 2.3.3.3 Хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээ хооронд шилжих, үйлчилгээний багц хооронд шилжих;
  - 2.3.3.4 Эзэмших эрх шилжүүлэх;
  - 2.3.3.5 Олон улсын роуминг үйлчилгээг идэвхжүүлэх, цуцлах;
  - 2.3.3.6 Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалтыг авах;
  - 2.3.3.7 Бусад нэмэлт үйлчилгээ;

### 2.4 Сарын суурь хураамж

- 2.4.1 Хэрэглэгч тухайн сард хэрэглээ хийсэн бол ашиглаж буй багцын сарын суурь хураамж бүтэн тооцогдоно.
- 2.4.2 Сарын аль ч өдөр шинэ хэрэглэгч болсон тохиолдолд зөвхөн тухайн сарын суурь хураамжийг Хавсралт 1-ийн 1.2-т заасан нөхцөлийн дагуу нэмжлэх бөгөөд багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.
- 2.4.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү сарын аль ч өдөр шилжсэн тохиолдолд сарын суурь хураамж бүтнээр тооцогдоно.
- 2.4.4 MULTI SIM үйлчилгээний сарын суурь хураамж 5000₮ ба холболт хийгдсэн дараа төлбөрт үйлчилгээний дугаарын төлбөр дээр нэмж бодогдоно.
- 2.4.5 MULTI SIM үйлчилгээнд холбосон симийг сарын турш хэрэглээгүй тохиолдолд сарын суурь хураамж бодогдохгүй.
- 2.4.6 Сарын суурь хураамж нь дараах нөхцөлүүдэд бодогдохгүй. Үүнд:
  - 2.4.6.1 Хэрэглэгч дугаар хадгалах үйлчилгээ авсан бол;

- 2.4.6.2 Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон бол;
- 2.4.7 Гар утас зээлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгчид 2.4.4.1, 2.4.3.2 заалтууд хамаарахгүй болно.
- 2.4.8 Хэрэглэгч сарын турш хэрэглээ хийгээгүй, дугаар хадгалах үйлчилгээнд бүртгүүлээгүй тохиолдолд Хавсралт 1-ийн 1.3-д заасан дугаар хадгалах үйлчилгээний төлбөр хэрэглээ хийгээгүй сар бүр нэхэмжлэгдэнэ.
- 2.5 **Багцын хэрэглээний эрх**
  - 2.5.1 Багцын дата эрхийг Скайтелийн 3G болон 4G LTE сүлжээнд ашиглах боломжтой ба дата эрх дууссаны дараах хэрэглээ нь Хавсралт 2-ын 2.3-т заасан загдай дата тарифаар тооцогдоно.
  - 2.5.2 Дараа төлбөрт үйлчилгээний дугаартаа MULTI SIM үйлчилгээг холбосноор багцад дагалдах дата эрхээ 3 хүртэлх төхөөрөмжид зэрэг ашиглана.
  - 2.5.3 MULTI SIM үйлчилгээнд холбосон төхөөрөмжүүдийг зөвхөн 4G LTE сүлжээнд ашиглах ба холболт хийсэн дараа төлбөрт дугаарын дата хурдаар ашиглах боломжтой.
  - 2.5.4 InLive үйлчилгээний загдай датаны хэрэглээ нь үнэ төлбөргүй байх ба Хавсралт 2-ын 2.2-т заасан хурдаар ашиглах боломжтой байна.
  - 2.5.5 Багцын ярианы эрхийг Скайтелийн сүлжээнд дэх яриа болон харилцан холболт бүхий дотоодын сүлжээнд ашиглах боломжтой бөгөөд зүй зохисгүй хэрэглээгээс сэргийлж зохист хэрэглээний хэмжээтэй байна.
  - 2.5.6 Багцын мессеж эрхийг Скайтелийн сүлжээнд болон харилцан холболт бүхий дотоодын операторуудын сүлжээнд ашиглах боломжтой ба зүй зохисгүй хэрэглээгээс сэргийлж, 1 өдрийн хэрэглээг 150 мессежээр хязгаарлана.
  - 2.5.7 Тусгай дугаарын яриа, видео дуудлага, Олон Улсын яриа болон Олон Улсын Роуминг үйлчилгээний ярианы хэрэглээ нь багцын ярианы эрхэд хамаарахгүй.
  - 2.5.8 Багцад дагалдах хэрэглээний эрхийг ашиглах нөхцөл. Үүнд:
    - 2.5.8.1 Тухайн сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн 1 сард шилжинэ.
    - 2.5.8.2 Багц шилжсэн тохиолдолд өмнөх сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
  - 2.5.8.3 Тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
  - 2.5.8.4 Багцад дагалдах дата эрхээ Скайтелийн сүлжээнд дэх урьдчилсан төлбөрт болон дараа төлбөрт үйлчилгээний дугаарт зааврын дагуу шилжүүлэх боломжтой.
- 2.6 **Үйлчилгээний хугацаа**
  - 2.6.1 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулсан өдрөөс эхлэн үйлчилгээний хугацааг тооцно.
  - 2.6.2 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг цуцалсан өдрөөс үйлчилгээний хугацаа дуусгаар болно.
- 2.7 **Сим карт сэргээх**
  - 2.7.1 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан 3000 төгрөг төлж энгийн 4G LTE сим картаа сэргээлгэнэ.
  - 2.7.2 Хэрэглэгч ашиглаж буй төхөөрөмжөө сольж өөр төхөөрөмжид eSIM-ийг ашиглах бол үйлчилгээний салбар, онлайн суваг ашиглан 5000 төгрөг төлж шинэ QR код худалдан авна.

## ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

### 3.1 Багц хооронд шилжих

- 3.1.1 Багц хооронд шилжих гэдэг нь дугаараа солихгүйгээр багцын төрлөө өөрчлөхийг хэлэх ба гар утас зээлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч багцаа бууруулах боломжгүй.
- 3.1.2 Багц хооронд шилжих үйлчилгээний хүсэлтийг сарын аль ч өдөр хүлээн авах бөгөөд үйлчилгээ нь зөвхөн дараа сарын 01-ний өдөр, идэвхтэй төлөвтэй дугаарт идэвхжнэ.
- 3.1.3 Үйлчилгээний үнэ тарифт заасан нөхцөлийн дагуу сонгосон багцад харгалзах барьцаа төлбөрийг байршуулан багц хооронд шилжих боломжтой.
- 3.1.4 Хэрэглэгч багц буурах тохиолдолд шатлан буурах зарчмаар шилжих ба багц ахиж тохиолдолд өөрийн хүссэн багц руу шилжих боломжтой.

### 3.2 Үйлчилгээ хооронд шилжих

- 3.2.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжихэд Хавсралт 2-ын 2.1-д заасан харгалзах багцын барьцаа төлбөрийг байршуулан дараа төлбөрт үйлчилгээний гэрээ байгуулна.
- 3.2.2 Хэрэглэгч урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжэхэд урьдчилсан төлбөрт нөхцөл дээр ашиглаж байсан үйлчилгээний хугацаа болон нэгж устана.
- 3.2.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжсэн хэрэглэгч дугаараа 3 сарын турш тасралтгүй идэвхтэй ашигласан тохиолдолд Урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой байх ба шилжих үед төлбөрийн үлдэгдэлгүй байна.
- 3.2.4 Хэрэглэгч дараа төлбөрт үйлчилгээнээс урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих үед үйлчилгээний хугацаа тухайн өдрөөр, дансандаа 0 төгрөгний нэгжтэй байна.

### 3.3 Дугаар хадгалах үйлчилгээ

- 3.3.1 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаарыг төлбөртэй нөхцөлөөр хадгалах боломжтой бөгөөд гар утас зээлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч дугаараа хадгалуулах боломжгүй.
- 3.3.2 Хэрэглэгч дугаар хадгалах үйлчилгээг үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншигчийн мэдээллийг өгч тухайн өдрөөс эхлэн хадгалуулах ба өмнөх төлбөр тооцоог бүрэн төлж барагдуулсан байна.
- 3.3.3 Дараа төлбөрт үйлчилгээний багцыг 3 ба түүнээс дээш сар ашигласан бол дугаар хадгалах үйлчилгээ авах боломжтой байна.
- 3.3.4 Хэрэглэгч жилд 1 удаа 1-3 хүртэлх сарын хугацаагаар дугаар хадгалах үйлчилгээг үнэ төлбөргүй авах эрхтэй. Бусад тохиолдолд сард 5000 төгрөгөөр 12 сар хүртэлх хугацаанд дугаар хадгалах үйлчилгээг авах ба үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлнө.
- 3.3.5 Хэрэглэгч сарын дундуур дугаар хадгалуулах хүсэлт гаргасан бол үйлчилгээний сарын суурь хураамжийг бүтэн нэхэмжлэн суурь хураамжид дагаад хэрхийг бүтэн олгоно.
- 3.3.6 Дугаар хадгалах хугацаа дуусахад дугаарын эрх автоматаар нээгдэх ба хэрэглээ хийгээгүй сар бүрт Хавсралт 1-ийн 1.3-д заасан төлбөр нэхэмжлэгдэнэ.
- 3.3.7 MULTI SIM үйлчилгээтэй дараа төлбөрт үйлчилгээний дугаарыг хадгалуулсан тохиолдолд холбосон симийг ашиглах боломжгүй болно.

### 3.4 Хэрэглэгчийн хүсэлтээр дугаар хаах, нээх

- 3.4.1 Хэрэглэгч гар утас болон сим картаа алдсан, үргэдүүлсэн тохиолдолд доорх сувгуудыг ашиглан 1-14 хоног үйлчилгээг түр хаах боломжтой ба шаардлагатай үед мөн нээж болно. Үүнд:
  - 3.4.1.1 Үйлчилгээний салбар;
  - 3.4.1.2 Skytel.mn болон Skytel app;
  - 3.4.1.3 Лавлагаа мэдээллийн төв;
  - 3.4.1.4 Киоск төхөөрөмж;
  - 3.4.1.5 Чат бот;
- 3.4.2 Сарын дундуур үйлчилгээ нээлгэх хүсэлт гаргаж байгаа тохиолдолд үйлчилгээний суурь хураамж бүтнээр бодогдож үйлчилгээний эрхийг бүтэн олгоно.
- 3.4.3 MULTI SIM үйлчилгээтэй дугаарыг 1-14 хоног хаасан тохиолдолд холбосон симийг ашиглах боломжгүй болох ба дараа төлбөрийн дугаарыг нээх үед холбосон симийг ашиглах боломжтой болно.

## ДӨРӨВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

### 4.1 Нэмэлт үйлчилгээ

- 4.1.1 Нэмэлт үйлчилгээний сарын суурь хураамж нь дараа төлбөрт үйлчилгээний багцын суурь хураамж дээр нэмэгдэнэ.
- 4.1.2 Нэмэлт үйлчилгээг сарын аль ч өдөр идэвхжүүлсэн үйлчилгээний төлбөр бүтэн тооцогдоно.
- 4.1.3 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг зааврын дагуу цуцлах хүртэл биллинг циклээр буюу сар бүр ашиглах боломжтой байна.
- 4.2 **Нэмэлт дата багц**
  - 4.2.1 Нэмэлт дата багцын үнэ тариф нь үйлчилгээ үзүүлэгчийн тухайн үеийн нөхцөлөөр зохицуулагдах ба 3G болон 4G LTE сүлжээнд ашиглах боломжтой байна.
  - 4.2.2 Нэмэлт дата багцыг сарын аль ч өдөр идэвхжүүлсэн багцын төлбөр бүтэн тооцогдох ба тухайн сарыг дуустал ашиглах хугацаатай байх бөгөөд багцаас хэтэрсэн хэрэглээ нь Хавсралт 2-ын 2.3-т заасан загдай тарифаар тооцогдоно.
- 4.2.3 Сар бүр автоматаар сунгагдах дата багц идэвхжүүлсэн тохиолдолд сар бүрийн үйлчилгээний суурь хураамж дээр дата багцын үнэ нэмж нэхэмжлэгдэх бөгөөд хэрэглэгч өөрөө мессежээр цуцлах хүртэл дата багц сар бүр автоматаар сунгагдана.
- 4.2.4 MULTI SIM үйлчилгээтэй дугаар нэмэлт дата багц идэвхжүүлсэн тохиолдолд холбосон төхөөрөмжүүдэд зэрэг ашиглана.
- 4.3 **Нэмэлт үйлчилгээ, дата багцыг идэвхжүүлэх, цуцлах**
  - 4.3.1 Нэмэлт үйлчилгээ болон дата багцыг доорх сувгуудыг ашиглан хэрэглэгч идэвхжүүлэх болон цуцлах боломжтой. Үүнд:
    - 4.3.1.1 Тусгай дугаарт түлхүүр үгийг илгээн мессежээр;
    - 4.3.1.2 \*123# дугаарт залгах /USSD/
    - 4.3.1.3 Skytel.mn болон Skytel app;
    - 4.3.1.4 Киоск төхөөрөмж;

- 4.3.1.5 Чат бот;
- 4.4 MULTI SIM-г холбох, цуцлах, шалгах**
- 4.4.1 MULTI SIM үйлчилгээг биет сим болон eSIM-ээр дараа төлбөрт үйлчилгээний дугаартай холбох болон цуцлахдаа дараах сүвгуудыг ашиглах боломжтой. Үүнд:
- 4.4.1.1 SKYtel anp;
- 4.4.1.2 Skytel.mn цахим хуудас;
- 4.4.1.3 Үйлчилгээний салбар;
- 4.4.1.4 123 дугаарт мессеж илгээж;
- 4.4.1.5 USSD /\*123#/;
- 4.4.2 Дараа төлбөрт үйлчилгээний дугаараас 123 дугаарт “Sim” гэж илгэсэнээр бүртгэлтэй симний тоо болон сериалыг шалгах боломжтой.

#### **ТАВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ**

- 5.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр, байгууллагын албан тоот хүсэлтийг үндэслэн үйлчилгээний салбарт хандана.
- 5.2 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд сар бүрийн 06-ны өдрөөс эхлэн шилжүүлэх бөгөөд нийт төлбөрийн үлдэгдлийг бүрэн барагдуулсан байна.
- 5.3 Эзэмших эрх шилжүүлсэн тохиолдолд хүлээн авсан хэрэглэгчтэй Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулна.
- 5.4 MULTI SIM үйлчилгээтэй Хэрэглэгч эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд холбосон сим автоматаар цуцлагдана.

#### **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ**

##### **6.1 Мессеж роуминг үйлчилгээ**

- 6.1.1 Мессеж роуминг үйлчилгээг байгууллага үйлчилгээний хэрэглэгч нэмэлт барьцаа төлбөр байршуулахгүйгээр ашиглах боломжтой бөгөөд мессеж хүлээн авахад үнэ төлбөргүй, илгээхэд тухайн улсын үүрэн операторын тарифыг мөрдөнө.
- 6.1.2 Мессеж роуминг үйлчилгээ нь байгууллага үйлчилгээний шинэ хэрэглэгч болох үед идэвхжих ба гадаад улс руу зорчихдоо тусгай дугаарт мессеж илгээн идэвхжүүлэх шаардлагатайгээр шууд ашиглах боломжтой байна.
- 6.1.3 Мессеж роуминг үйлчилгээг ашиглаагүй тохиолдолд нэмэлт төлбөр бодогдохгүй.
- 6.1.4 Мессеж роуминг үйлчилгээний тариф нь тухайн зорчих бүс нутаг болон орнуудаас шалтгаалан харицан адилгүй байх ба тухайн үнэ тарифтай хэрэглэгч заавал танилцсан байх үүрэгтэй.
- 6.1.5 Хэрэглэгч тусгай дугаарт мессеж илгээн мессеж роуминг үйлчилгээг хаах мөн буцаан идэвхжүүлэх боломжтой. Үүнд:
- 6.1.5.1 Мессеж роуминг үйлчилгээг цуцлах бол 599 дугаарт “Off” утга илгээнэ.
- 6.1.5.2 Мессеж роуминг үйлчилгээг идэвхжүүлэх бол 599 дугаарт “Sms” утга илгээнэ.

##### **6.2 Яриа-мессеж роуминг**

- 6.2.1 Дараа төлбөрт хэрэглэгч Яриа-мессеж роуминг үйлчилгээний эрх нээлгэхдээ үйлчилгээний салбарт хандан, Хавсралт 2-ын 2.4-т заасан барьцаа төлбөрийг байршуулна.
- 6.2.2 Хэрэглэгч 12 сар болон түүнээс дээш хугацаанд дугаараа идэвхтэй ашигласан тохиолдолд Яриа-мессеж роуминг үйлчилгээг Олон Улсын Роумингийн барьцаа байршуулахгүй ашиглана.
- 6.2.3 Яриа-мессеж роуминг үйлчилгээг 6.2.1 болон 6.2.2-т заасан хэрэглэгч 599 дугаарт “call” гэсэн мессежийг илгээн идэвхжүүлэх боломжтой.

##### **6.3 Цогц роуминг үйлчилгээ**

- 6.3.1 Цогц роуминг үйлчилгээг зөвхөн дараа төлбөрт үйлчилгээний 3G болон 4G LTE сүлжээний хэрэглэгч Хавсралт 2-ын 2.4-т заасан барьцаа төлбөрийг байршуулан Олон улсын Роуминг үйлчилгээний Гэрээ байгуулан ашиглах боломжтой бөгөөд дараах үйлчилгээг ашиглана. Үүнд:
- 6.3.1.1 Дүүдлага хийх, хүлээн авах;
- 6.3.1.2 Мессеж илгээх, хүлээн авах;
- 6.3.1.3 Дата /интернет үйлчилгээ/ ашиглах;
- 6.3.2 Хэрэглэгч цогц роуминг үйлчилгээний эрхийг салбарт хандан Хавсралт 1-ийн 1.4-т заасан бичиг баримтад үндэслэн идэвхжүүлнэ.

##### **6.4 Дата роуминг багц**

- 6.4.1 Дата роуминг багцын үйлчилгээг Олон улсын Роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгч авах боломжтой ба дата роумингийн үндсэн багцуудыг Хавсралт 1-ийн 1.5-д заасан нөхцөлөөр тусгай дугаарт мессеж илгээн идэвхжүүлэн ашиглана.
- 6.4.2 Дата роуминг багцын харгалзах эрхээс хэтэрсэн дата хэрэглээг Олон улсын Роуминг үйлчилгээний задгай датаны хэрэглээний тарифаар тооцон нэхэмжилнэ.
- 6.4.3 Дата роуминг багцуудыг давхар идэвхжүүлсэн тохиолдолд багцууд зэрэг идэвхжих бөгөөд хэрэглэгчийн аль улсад байгаагаас хамаарч харгалзах улсын багцаас хэрэглээг тооцно.
- 6.4.4 Дата роуминг багцын хэрэглээ болон дуусах хугацааг шалгахдаа 599 тусгай дугаарт “data” утга илгээнэ.
- 6.5 Хэрэглэгч Олон Улсын Роуминг үйлчилгээг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд:
- 6.5.1 Хэрэглэгч зорчих улсынхаа үүрэн операторын Олон Улсын Роуминг үйлчилгээний яриа, мессеж, дата үйлчилгээний тарифтай урьдчилан танилцсан байна. (www.skytel.mn – Бүтээгдэхүүн үйлчилгээ – ОУ-ын үйлчилгээ – Роуминг үйлчилгээ, 1515 лавлах төв)
- 6.5.2 Олон Улсын Роуминг үйлчилгээний тарифын мэдээллийг 599 тусгай дугаарт тухайн улсын Олон Улсын нэрний эхний 4 үсгийг /Латин үсэг/ мессежээр илгээн авах боломжтой.
- 6.5.3 Хэрэглэгч 1510 тусгай дугаарт “R” үсгийг илгээн Олон Улсын Роуминг үйлчилгээний хэрэглээг шалгана.
- 6.5.4 Өөр операторын сүлжээнд байхдаа хэрэглээ шалгах тариф нь тухайн орны Олон улсын Роуминг үйлчилгээний мессеж илгээх тарифаар тооцогдоно.
- 6.5.5 Хэрэглэгч хэрэглээгээ тогтмол хянаж, гарсан төлбөр тооцоог бүрэн хариуцна.
- 6.5.6 Олон Улсын яриа үйлчилгээний барьцаа болон Олон Улсын Роуминг үйлчилгээнд байршуулсан барьцаа дүнгээс хамааран дотоод, гадаад хэрэглээ Хавсралт 2-ын 2.4-т заасан нөхцөлөөр хязгаарлагдана.

#### **ДОЛОО. ХЭРЭГЛЭЭНИЙ ХЯЗГААР**

- 7.1 Багад дагалдах дата эрх дуусч дата хэрэглээ задгай дата хэрэглээ рүү шилжихэд ашиглаж буй үйлчилгээний багцаас хамааран задгай дата хэрэглээг Хавсралт 1-ийн 1.6-д заасан хэмжээнд хүрсэн тохиолдолд хязгаарлана.

#### **НАЙМ. ТӨЛБӨР ТООЦОО**

##### **8.1 Ярианы минутын алхам тооцоолол**

- 8.1.1 Монгол улс доторх яриаг 1 (нэг) минутын алхмаар тооцох бөгөөд нэг минут хүрээгүй яриаг нэг бүхэл минутаар тооцно. Хэрэглэгчийн хэрэглэж буй үйлчилгээний багцаас хамаарч нэг минутын тариф харилцан адилгүй байна.
- 8.1.2 Олон улсын яриа нь эхний бүрэн ба бүрэн бус 6 (зургаан) секунд хүртэлх яриаг 6 секундээр, 7дахь секундээс 1 секундын алхмаар тооцогдох бөгөөд холбогдож буй улсаас хамаарч нэг минутын ярианы тариф харилцан адилгүй байна.

##### **8.2 Хэрэглээний мэдээлэл**

- 8.2.1 Хэрэглэгч сар бүрийн 06-ны өдрөөс хойш 1510 тусгай дугаарт В үсгийг мессежээр илгээж хэрэглээний төлбөрийг, U үсгийг мессежээр илгээж хэрэглээний мэдээллийг, D үсгийг илгээж дата хэрэглээний талаарх мэдээллийг тус тус мессеж хэлбэрээр авах боломжтой.
- 8.2.2 Олон улсын роуминг үйлчилгээний тарифын мэдээллийг 599 тусгай дугаарт тухайн улсын нэр эсвэл эхний 4 үсгийг мессежээр илгээж мессеж хэлбэрээр авах боломжтой.

##### **8.3 Төлбөр тооцоо**

- 8.3.1 Байгууллагын үйлчилгээний хэрэглэгч /байгууллага/ нь нэхэмжилсэн төлбөр тооцоог гэрээнд заасан хугацааны дагуу цаг тухайд нь төлнө.
- 8.3.2 Дараа сарын 20-ны дотор өмнөх сарын төлбөрөө төлөөгүй тохиолдолд сар бүрийн 20-нд гарах хэрэглээ, сарын сүүлийн өдөр бүх хэрэглээ хязгаарлагдана.
- 8.3.3 Дугаарын үйлчилгээ хязгаарлагдсанаас хойш 180 хоногийн турш хадгалах ба 181 дэх хоногоос үйлчилгээ үзүүлэгчийн 1 талын саналаар дугаарыг худалдаанд гаргах боломжтой.
- 8.3.4 Дугаарын үйлчилгээ хязгаарлагдсанаас хойш 120 хоногийн турш төлбөр төлөлт хийгдээгүй бол Байгууллагын үйлчилгээний гэрээнд заасны дагуу хувь хэрэглэгч болон байгууллагын мэдээллийг цуглуулан Эзэлийн мэдээллийн санд бүртгүүлнэ.

##### **8.4 Төлбөр төлөх боломж**

- 8.4.1 Хэрэглэгч ашигласан хэрэглээний төлбөрийг сар бүрийн 20-ны дотор доорх сүвгуудаас сонгон төлөх боломжтой. Үүнд:
- 8.4.1.1 Үйлчилгээний салбарт хандах;
- 8.4.1.2 www.skytel.mn цахим хуудас, Skytel болон банкны аппликэйшн ашиглах;
- 8.4.1.3 КИОСК төхөөрөмж ашиглах;
- 8.4.1.4 Чат бот;
- 8.4.1.5 Скайдилерт хандах;
- 8.4.1.6 Сервис дилерт хандах;
- 8.4.1.7 Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны АТМ-ээр;
- 8.4.1.8 Дараа төлбөрт үйлчилгээний нөхцлийн Хавсралт 2-ын 2.6-д заасан банкны автомат данс ашиглах;

#### **ЕС. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСООХ**

- 9.1 Тухайн сарын хэрэглээний төлбөрийг дараа сарын 20-ны дотор төлөөгүй тохиолдолд сарын сүүлийн өдөр хүртэл гарах үйлчилгээний эрхийг зогсоож, орох үйлчилгээний эрхийг хэвээр үлдээх бөгөөд сарын сүүлийн өдөр орох, гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсооно.
- 9.2 Багцаас хэтэрсэн яриа, мессеж, дата хэрэглээний төлбөр хэрэглээний хязгаарлалтын дүнд хүрсэн

тохиолдолд гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсоох ба орох үйлчилгээний эрх нээлттэй байна.

- 9.3 MULTI SIM үйлчилгээтэй дугаар төлбөрийн улмаас болон хэрэглээний хязгаарлалтанд хүрээд хаагдсан тохиолдолд холбосон симийг ашиглах боломжгүй болно.

#### **АРАВ. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- 10.1 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцалж болно. Үүнд:
- 10.1.1 Гэрээнд заасан аль нэг үүргээ биелүүлээгүй бол;
- 10.1.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дуусгавар болсноор;
- 10.1.3 Хэрэглэгчийн хүсэлтээр;
- 10.1.4 Хуульд заасан бусад үндэслэлээр;
- 10.2 Хэрэглэгч гэрээг цуцлах тухай саналыг Үйлчилгээ үзүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.
- 10.2.1 MULTI SIM үйлчилгээтэй дугаарын гэрээг цуцлах үед холбосон сим автоматаар цуцлагдана.
- 10.3 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах тохиолдолд үйлчилгээний хариуцлага хүлээх шаардлагатай бичиг баримтыг авчран дараах төлбөрүүдийг төлж санхүүгийн үйлчилгээг зогсооно. Үүнд:
- 10.3.1 Гэрээг цуцлах хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний нийт төлбөр;
- 10.3.2 Бусад төлбөр, зардлууд;
- 10.4 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон дугаар хадгалуулах үйлчилгээ аваагүй тохиолдолд тухайн дугаарыг төлбөрийн улмаас идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 181 дэх хоногт төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцан барагдуулна.

#### **АРВАН НЭГ. БУСАД**

- 12.1 Энэхүү дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд шууд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

## 1.1 Энгийн азын ,алтан дугаар

Дугаарын төрөл		Нэмэлт төлбөр
Энгийн	ABCD	10,000₮
Азын	AABB, ABAB, ABBA, AAAB, BAAA	60.000₮
Алтан	9BAA-9BAA	300.000₮
	AAAA	500.000₮

## 1.1.1 Үнэ цэнэтэй дугаар

Дугаарын төрөл		Нэмэлт төлбөр	
9111**** 9191**** 9000**** 9090****	Энгийн	50.000₮	
	Азын	AABB, ABAB, ABBA, AAAB, BAAA	100.000₮
	Алтан	AAAA	800.000₮
		9BAA-9BAA	

## 1.2 Шинэ хэрэглэгчийн суурь хураамж тооцох

Шинэ хэрэглэгч болсон өдөр	Сарын суурь хураамж тооцох хувь
1-10-ны өдрүүдэд	100%
11-20-ны өдрүүдэд	50%
21-31-ний өдрүүдэд	30%

## 1.3 Суурь хураамж тооцох

Хэрэглээ хийгээгүй үед тооцох нөхцөл	Сар бүр 5000₮
--------------------------------------	---------------

## 1.4 ОУ-ын үйлчилгээ идэвхжүүлэхэд шаардлагатай бичиг баримт

Байгууллагын хэрэглэгч	Цахим үнэмлэх эсвэл хурууны хээ уншуулах, тоон гарын үсэг зурах, байгууллагын албан хүсэлт
------------------------	--

## 1.5 Дата роуминг багц

Багцын нэр	Ашиглах хугацаа	Дата хэмжээ	Ашиглах улс	Үнэ тариф	Тусгай дугаар	Илгээх утга
48 цагийн багц	48 цаг	200MB	АНУ-USA, Канад-Canada	39.000₮	599	AMERICA 48
			Их Британи-UK, Орос-Russia, Франц-France, Герман-Germany	39.000₮		EUROPE 48
			Солонгос-Korea, Макао-Macau, Хонг Конг-Hong Kong, Хятад-China	39.000₮		ASIA 48
7 хоногийн ЧАТ багц	7 хоног	450MB	АНУ-USA, Канад-Canada	79.000₮		AMERICA CHAT
			Их Британи-UK, Орос-Russia, Франц-France, Герман-Germany	79.000₮		EUROPE CHAT
			Солонгос-Korea, Макао-Macau, Хонг Конг-Hong Kong, Хятад-China	79.000₮		ASIA CHAT
1GB дата	7 хоног	1GB	АНУ-USA, Канад-Canada, Их Британи-UK, Герман-Germany, Франц-France, Макао-Macau, Хятад-China	120.000₮		
4GB дата	14 хоног	4GB		479.000₮		4GB

## 1.6 Задгай дата хэрэглээг хязгаарлах нөхцөл:

Багц	Задгай дата хэрэглээг хязгаарлах хэмжээ
Монголдоо 10/ Байгууллага 8000	5GB
Монголдоо 20/Монголдоо 20 (6.0)	
Монголдоо 30/Монголдоо 30 (6.0)	10GB
Монголдоо 40/ Монголдоо 40 (6.0)	
Монголдоо 70/ Монголдоо 70 (6.0)	
Монголдоо 100/ Монголдоо 100 (6.0)	

2.1 Үндсэн үнэ						
Багц	МОНГОЛдоо	МОНГОЛдоо 6.0				
	10	20	30	40	70	100
Багцын сарын суурь хураамж	10.000₮	20.000₮	30.000₮	40.000₮	70.000₮	100.000₮
Багцын дагалдах дата	200MB	6GB	12GB	24GB	70GB	150GB
Бүртгэлийн хураамж	10000₮					
Үндсэн барьцаа	20.000₮		30.000₮	50.000₮		
MULTI SIM үйлчилгээний сарын суурь хураамж	-	5000₮				
Багц	InLive					
	12	25	35	50	65	90
Багцын сарын суурь хураамж	12.000₮	25.000₮	35.000₮	50.000₮	65.000₮	90.000₮
Багцад дагалдах дата	15GB	25GB	40GB	60GB	90GB	130GB
Үндсэн барьцаа	0₮	0₮	0₮	0₮	0₮	0₮
Багцад дагалдах MULTI SIM	-	-	1 сим	1 сим	1 сим	1 сим
MULTI SIM үйлчилгээний сарын суурь хураамж	5000₮					

2.2 InLive үйлчилгээний задгай дата хэрэглээний тариф			
Багц	Дата хэмжээ	Хурд	Үнэ
InLive 12	15GB	Хязгааргүй	0₮
	∞	256kbps	
InLive 25	25GB	Хязгааргүй	
	∞	256kbps	
InLive 35	40GB	Хязгааргүй	
	∞	256kbps	
InLive 50	60GB	Хязгааргүй	
	∞	256kbps	
InLive 65	90GB	Хязгааргүй	
	∞	256kbps	
InLive 90	130GB	Хязгааргүй	
	∞	256kbps	

2.3 Яриа, мессэж, задгай дата хэрэглээний тариф		
МОНГОЛдоо, Байгууллага 8000		InLive
Сүлжээ харгалзахгүй яриа	50₮	60₮
Сүлжээ харгалзахгүй мессэж	20₮	20₮
Задгай дата /мегабайтаар/	1MB тутамд 6₮	1MB тутамд 0₮

2.4 Олон Улсын үйлчигээ	Барьцаа төлбөр	Хэрэглээ хязгаарлах
Олон Улсын ярианы үйлчилгээ	Үндсэн барьцаа+100.000₮	100.000₮
	Үндсэн барьцаа+200.000₮	200.000₮
Яриа-мессэж хосолсон роуминг	*	200.000₮
	Үндсэн барьцаа+100.000₮	200.000₮
Цогц роуминг	Үндсэн барьцаа + 350.000₮	500.000₮
	Үндсэн барьцаа + 500.000₮	Хязгааргүй

2.5 Захиалгат үйлчилгээний төлбөр	
Багц хооронд шилжих /Буурах, ахих/	Төлбөргүй
Дугаарын сүүлийн 4 орон солих	20.000₮
Дугаар хадгалах	Хуанлийн 1 жилд 3 сар үнэгүй, 4 дэх сараас эхлэн сар бүр 5.000₮
Сим карт сэргээх	3.000₮
MULTI SIM бүртгэлийн хураамж	3.000₮
eSIM бүртгэлийн хураамж	5.000₮
eSIM QR код дахин авах	5.000₮
Үйлчилгээ хооронд шилжих/УТУ-с ДТУ-рүү, ДТУ-с буцаж УТУ-рүү /	Төлбөргүй

2.6 Дансны мэдээлэл	
ХХБ банк	499 120 987
Хас банк	500 167 8218
Хаан банк	503 801 9105
Голомт банк	110 204 6354
Төрийн банк	106 000 002 84